

ОРЧУУЛГЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУДЫГ ШҮҮМЖИД ТУСГАСАН НЬ

М.Амартайван⁵²

Товч утга: “Марк Твений минь махы нь идэж дээ” номд орсон өгүүллүүдэд Б.Ринчен тухайн үеийн орчуулгын тулгамдсан асуудлуудыг хэрхэн тусгасныг тоймлон үзнэ.

Түлхүүр үг: орчуулгын шүүмж, орчуулгын тулгамдсан асуудал, уран зохиолын орчуулга, орчуулгын чанарыг сайжруулах, орчуулах эрдэм, орчуулгын өв

Энэ цагт орчуулга сонирхох хүн олширсон ч орчуулгад шамдан суралцагч нь хэд вэ? Орчуулга гарын үзүүрээр хийгээд гайгүй мөнгө атгадаг ажил мөн үү? Муу үг модон улаатай гэдэг шиг “муу орчуулга модон улаатай” биш гэж үү? Энэ мэт асуултын хариуг эрж хайх хүн байвал эндэлгүй хариу барих нэгэн ном бийг дуулгая. Дуун хөрвүүлэгч Г.Аким эмхтгэн хэвлүүлсэн их эрдэмтэн Бямбын Ринчений бичсэн орчуулгын тухай нийтлэл, өгүүлэл, шүүмжийн түүвэр “Марк Твений минь махы нь идэж дээ” ном бол орчуулах эрдэмд шимтэгч бүхний ахин дахин үзэх ном яах аргагүй мөн билээ. Тус өгүүлэлд их эрдэмтний энэ түүвэрт тухайн үеийн орчуулгын тулгамдсан асуудлууд хэрхэн тусгагдсаныг тоймлон авч үзнэ.

Юуны өмнө Б.Галаарид залуу орчуулагчид зөвлөхдөө: Манайд орчуулахуйн урлагийн төлөө санаа тавьж, үлгэр үзүүлж байсан хамгийн том төлөөлөгч нь Бямбын Ринчен гуай. Түүний “Эх хэлээ энхрийлж, үгний боловсролыг эрхэмлэе”, “Марк Твений минь махыг нь идэж дээ”, “Шүлэг орчуулах эрдэм”, “Энэтхэг яруу найргийн амт үнэрийг үлдээхсэн гэж...” гэхчлэн олон өгүүллийг манай мундаг орчуулагчдын нэг Г.Аким гуай 1991 онд эмхтгэн “Марк Твений минь махыг нь идэж дээ...” нэртэйгээр хэвлүүлсэн нь одоо хуучин номын дэлгүүрт хямдхан зарагдаж байна лээ. Гадаад хэлний боловсрол нэмэгдсэн, хэрэглээ ихэссэн, орчуулга хийхийг хүсэгчид олширсон энэ цаг үед хамгийн үнэтэй номын л нэг байх учиртай юмсан. Орчуулга, ялангуяа уран сайхны орчуулга хийх гэж байгаа залуус минь энэ номыг хэрэг болгоод нэг умшчихаарай.⁵³ гэж зөвлөсөн байдгийг энд дурдахад илүүдэхгүй мэт санагдана.

Г.Аким “Бэрх утгыг мэдэн чадагч” хэмээх оршилдоо В.И.Лениний “Орос хэлийг цэвэрлэн ариутгах тухай” өгүүллийг Б.Ринчен 1934 онд орчуулж, хэлээ бохиртуулахгүй байхыг сануулсан оршил бичсэнээр европ зүгийн хэлнээс хийх орчуулгын онол, шүүмжийн “шавыг” босгосон гэж үзжээ. Тэнд өгүүлсэн нь:

⁵² ОУУБИС, магистр

⁵³ <http://galaarid.blogspot.com/2006/12/2.html> (Б.Галааридын блог) “Залуу орчуулагчид өгөх зөвлөгөө-2

“Хянаваас улс гэрийн соёлыг хөгжүүлэн өрнүүлэхэд хэлнээс эрхэм нь үгүй. Гэтэл манай зарим бичгийн зохиолын үг үсэг ойрхноос баахан цалгай болж эвдрэн буй мэт. Иймд хүрсний шалтгаан нөхцөлийг мохоон байцааваас түүний их төлөв нь гадаадын үгийг хэрэглэмгүй газар дэмий л зарж утгыг балар битүүлэг болгох нэгэн зүйл, аливаа бичиг харыг монголчлон орчуулахууд гадаад улсын үгийн нарийн гүн утга санааг мөчид дутуу ухаж, монгол үгийн дүрэм найруулал, зүй хэмжээнд нийлүүлэн буулгаж чадахгүй хоёр зүйл, монгол зохиолд энэ хоёр ослыг мөрдөн дууриааж бахдан дагалдсаар бичиг зохиолын утгыг будлиан, санааг балар болгох гурван зүйлийн үндсэн гэм буй ажээ”.

Г.Чулуунбаатарын онож тодорхойлсончлон, “Б.Ринчен багштан монгол орчуулгын, ялангуяа европ зүгийн хэлнээс буулгах орчуулгын онол, аргагүйг боловсруулах, орчуулгын шүүмж судлалыг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан юм”⁵⁴. Ингээд зарим өгүүлэл шүүмжид орчуулгын тулгамдсан асуудлыг хэрхэн тусгасныг үзье.

“Орчуулгын чанарыг дээшлүүлэх тухай”⁵⁵

Энэ өгүүлэлд орчуулах хөрвүүлэхийн чухлыг нэн түрүүнд бичиж сэнхрүүлснийг тоймлон дурдвал, олон улсын эрдэм соёлын бүтээл туурвилуудыг бид голдуу орчуулан хөрвүүлснийг үздэг гээд, урьд дорно дахины бичиг зохиолоос монгол хэлээр орчуулсан нь их⁵⁶ бол одоо цаг өөр болж өрнөдийн шинэ соёл боловсролын зүйлээс авах ээлж ирсэн тул орчуулах хөрвүүлэх нь мөн эрхэм чухал болсныг орчуулагч нар ухамсарлах ёстой гэжээ.

Тэгээд хааш яаш орчуулснаар монгол хэл бичгийг гутаан эвдэж буйг нэгд, гадаадын нэр томъёог ташаа бичиж, тухайлбал, удаа дараа гаргасан газарзүйн сурах бичгүүдэд газар орны нэрсийг зүйл зүйлээр бичиж байгаа нь сурах сургах хүнд юутай зовлонтой, хоёрт, монгол нэр томъёоны зүйлийг хэрэглэж чаддаггүйг, заримдаа монгол нэр байсаар атал тохиромж муутай шинэ нэр томъёо зохиох буюу дэлгэрсэн монгол нэрийг хэрэглэлгүй, огт хамаагүй өөр юмны нэр өгөх дуртай, бас монгол нэр байсаар атал гадаадын нэрийг хэрэглэх буюу дан монголоор нэрлэж болох атал монгол гадаад хоёрыг хутган хэрэглэх зүйл цөөнгүй, гадаад хэлний үг найруулгыг “хүн хорхойчлон” дуурайн хуулдаг, гуравт, орчуулагчдын үг болхи ядуу, орчуулсан нь монгол үгийн найруулгын зүйд харшилдгийг, үг цөөн орчуулагч нарын орчуулгаар бол гадаадын нэг үгэнд нэгээс илүү утга байхгүй мэт бөгөөд орчуулагчдын олонх нь утга санаа харилцан ойр үгсийн зүйлээр ядуугаас ядуу, дутуугаас дутуу амой гээд, жишээлбэл вопрос гэхийг гагц асуудал гэж орчуулдаг, энэ үг асуудал гэхээс гадна бас зүйл, явдал, байдал, тухай гэх зэрэг утгатайг мэдэж, орчуулах бүр тухайн утгыг

⁵⁴ Чулуунбаатар Л., Орчуулгын тухай лекцүүд, МУИС, УБ, 2017

⁵⁵ Ринчен Б., Орчуулгын чанарыг дээшлүүлэх тухай, “Марк Твений минь махы нь идэж дээ”, УБ, 1991, 14-32-р тал.

⁵⁶ Дорнын хэлнээс монголоор орчуулсан өв уламжлалын тухай дэлгэрэнгүйг уншихыг хүсвэл Хүрэлбаатар Л., Монгол орчуулгын товчоон: Сонгодог орчуулгын зарчим уран чадварын асуудалд, 1995. номоос үзнэ үү.

нэвтрүүлэх монгол үгийг сонгон хэрэглэж санааг уламжилбал зохино гэж зөвлөснийг орчуулгад анх суралцаж байгаа хүн бүр ямагт санаж явууштай. Бас аливаа хэлний үгэнд хэд хэдэн салаа утга байж болох тул өөр нэгэн хэлээр орчуулбаас бүгд утгыг бүрэн багтаасан гагц үгийг тэр бүр олж орчуулах нь түмэн бэрх хэрэг гэж сануулжээ. Мөн зарим тааруу орчуулгыг үзвэл орчуулагч нь өөрөө ойлгоогүй, сайн ойлгохыг ч хүсэхгүй, гараас бушуухан гаргаж биеэс зайлуулах хэмээсэн мэт хааш яаш орчуулж байна. Орчуулахын урьтал нь ойлгох байтал ойлголгүйгээр орчуулна гэж яавч байж болшгүй.

Их эрдэмтэн нийтийн боловсролд зориулсан бичиг сэлтэд албархуу үгээр орчуулсныг бас шүүмжилжээ. Жишээ болгон, арьсыг арчлах явдал чухал, арьсны гүйцэтгэх ажил гэснийг дурдсан нь одоо ч зарим хүний давтсаар байгаа алдаа бус уу? Цааш нь юм болгоныг орчуулах гэж зүтгэх нь чадлаас хэтийдсэн хэрэг учир аль нэг чиглэлээр мэргэжиж, зохих найруулгаар нь орчуулах зүйтэйг өгүүлснээс үзвэл одоо цагт “Бүх төрлийн орчуулга хийнэ” гэсэн сүржин зарын цаана яаж сүйдэлж орчуулга, орчуулагчийн нэрийг гутааж байгаа бол гэж бодохоос яс хавтайм. Барахгүй ажлаа бүдүүн зүрхээр зүтгүүлэхийг “*давирхайн саванд цай чанасан буюу, хурц хутгаар нарийн сийлвээс зохих юмыг түлээ хагалдаг иргүй сүхээр балбаж хийсэн мэт болой*” гээд, энэ бүхнийг орчуулагч цөөн гэсэн нэрийдлээр халхавчлахыг тун базаахгүй тул засаж залруулах ёстой гэсэн байна.

Шүүмжлээд зогсохгүй орчуулгын чанарыг хэрхэн сайжруулахын тухайд, 1) гадаадын нэрийг нэг л янзаар галиглах, 2) нэр томъёог орчуулахдаа монгол хэлэнд буй тогтсон нэрийг бүрэн хэрэглэн, хэлний баялгийг ашиглах, мэргэжлийн хүнээс асууж зөвлөлдөх, нэр томъёоны дэвтрийг хэрэглэх зэргээр аливаа нэр томъёоны зүйлийг цөм нэгэн мөр болгох, 3) орчуулагч нар үүргээ ухамсарлаж, эх хэл, гадаад хэлний мэдлэг чадвараа арвитгах, нэрт бичиг зохиол, толь бичгээс үзэх, ялангуяа монгол хэлний ёс найруулгад боловсрох, 4) орчуулгыг хэвлэхийн өмнө монгол хэл бичгийг сайн мэдэх бөгөөд зохиох найруулахууд чадвартай хүнээр хянуулж засах, 5) сурах бичгийг алдаа мадаггүй гаргах гэж тухайлан дурдаж заан сургажээ.

Өнөөгийн бидэнд ч хамгаас дутмаг байгаа зүйлийг “Орчуулагч нар нэгэн санаа, хамтын хүчээр орчуулгыг сайжруулахын зүг хандваас хэдүй цөөн хэмээн мөхөсдөх газаргүй бөгөөд залган гарах залуу эрдэмтэн олон орчуулагч нарт эрхэм дууриал сайн үлгэр болном бус уу” гэж тов тодорхой хэлсэн байна. Энэ нь Солонгосын орчуулгын онолын нэгэн бүтээлд⁵⁷, орчуулагч хэлмэрч хүн аливаа харилцааг эрхэмлэж, чөлөөтэй бодож сэтгэж, багаар ажиллаж, эх хэлээ тасралтгүй сурч, гадаад хэлийг чамбай эзэмшиж, орчуулах сэдвээ хангалттай мэддэг чадваруудтай байх ёстой гэсэнтэй утга санаа нэг ажээ.

⁵⁷ 최정화, 21 세기의 최고의 전문직 통역 번역사에 도전하라, 넥서스, 2012

“Эх хэлээ энхрийлж, үгний боловсролыг эрхэмлэе”⁵⁸

Эх хэлний найруулгад суралцахад хятад хэлнээс орчуулсан зохиол үлгэр дуурайл болно гэж энэ өгүүлэлдээ бичсэнийг сийрүүлбэл, Монгол “номын хэлийг” хятадаас орчуулсан уран зохиолын хэлтэй харшуулж үзвэл, хятад орчуулгын монгол хэл найруулга нь бахдам гайхам сайхан найруулгатай тул хятад нэр гардгаар л, энэ чинь жинхэнэ монгол зохиол биш, орчуулсан юм байна гэж мэдэхээс, яг л монгол сайхан хэл найруулгатай байдаг нь гайхалтай шүү. Түүнчлэн Монгол аман зохиол их өв соёлоосоо суралцахын чухлыг ч онцлон тэмдэглэхээ мартсангүй.

Тэгээд Солонгост 1954 онд 5 эрдэмтэн хамтарч амьтны 3300 нэрийг тогтоож толь гаргасан шиг амьтан ургамлын нэрийн толь гаргах хэрэгтэй байгааг дурджээ. Үнэхээр амьтан ургамлын нэр орчуулна гэдэг яггүй давааны нэг бөгөөд, шинжлэх ухаанд хэрэглэдэг латин нэрээр хөөж олох нь арай ойр тусдагийг санууштай.

Жүжигчин, багш, илтгэгч, лектор зэрэг хүмүүс сул үг хэрэглэх, буруу хазгай дуудаж сурснаа залруулж сонсогч олныг хүндлэх учиртай гэжээ. Нийтийн хэлний боловсролд олон хүнтэй харьцдаг эдгээр ажил мэргэжлийн хүмүүс үг яриагаа зөв боловсон болгоход анхаарвал их л хэрэгтэй юмсан. Сонины хэл ядмаг байгааг ч анхаарах ёстой байна. Орчуулагч нар өөрийнхөө хэлний зүй тогтлыг хайхраагүйгээс болж ач холбогдол өгнө гэж орос хэлний придавать значение гэдгийг буруу орчуулж, монголоороо холбогдол өх гэж болдоггүйг боддоггүй. Энэ мэт алдаа маш их, монгол хэлээ мэддэг хүн үзэж сонсвол, монголоор ингэж хэлдэггүй, энэ лав орчуулсан байх гэж дорхноо танигддаг. Бас эх зохиолын утга хэлбэр нь хоорондоо хэлхээ нэгтэй юм гэдгийг танин мэдэж, түүний үгийн утгыг хойдох урдах үгийн утга учиртай туйлын нарийн нямбай авалуулан орчуулах их эрдэм чадалтай, ёстой боловсорсон хүн бидэнд чухлаас чухал болоод байна гэсэн нь орчуулгын онолд чухлаар яригддаг хам сэдвийн асуудлыг хөнджээ. Зарим оюутан “Багш аа, энэ үгийг монголоор юу гэх вэ?” гээд дан үг бичсэн цаас үзүүлдэг нь ямар утгаар яаж хэрэглэсэн үг вэ гэдгийг таньж мэдэхэд бэрх болгодог нь мөнөөх хам сэдэв орхигдсоных билээ.

Эрдэм чадалтай орчуулагч аяндаа урсгалаараа гарч ирнэ гэж хүлээх нь гэнэн бодол учир тэнхим сургууль байгуулж орчуулгыг хянах, зөвлөх, шүүмж бичих ажил хийвэл их л тустайг бас энд өгүүлжээ. Харин этгээд хэлт, болхи найруулгатныг олон нийгээр жигшээх сэхээрүүлэх тухайд цахим сүлжээнд “Зугаатай хэлшинжлэл” бүлэг зохих үүргээ гүйцэтгэж, хэл шинжлэлийн багш нараас тухайлбал, М.Саруул-Эрдэнэ, М.Баярсайхан нар зөвлөгөө тайлбар хэлж байгаа нь нийтийн боловсролд нэн тустай байгааг энэ ялдамд дурдъя.

⁵⁸ Ринчен Б., Эх хэлээ энхрийлж, үгний боловсролыг эрхэмлэе, “Марк Твенний минь махы нь идэж дээ”, УБ, 1991, 45-80-р тал.

“Марк Твений минь махы нь идэж дээ”⁵⁹

Найруулан засагч хүн нэгд, эх бичигт гарч байгаа нэр томъёонд тохирох монгол түүхэн нэр томъёо олж, орчуулгад тэр ёсоор хэрэглэсэн эсэхийг хянаж, гуравт уг монгол орчуулгын үг найруулгыг хэлний зүйтэй нийцүүлэх үүрэгтэй гээд, энэ зохиолын орчуулгад монгол хэлэнд нэрийн зүйлд олны тэмдэг хэрэглэдэг зарчмыг огт ухаараагүй болон бас бус эндэл байгаа ч өдий төдий оюутан энэ номыг нийлж орчуулсанд нь талархаад, дутуу дулим зүйлийг зассан минь муучлах гэж заасан биш, хэтийн явдалд тустай гэж бичлээ гэж төгсгөжээ.

“Зохиол ч биш орчуулга ч биш”⁶⁰

Намсайн орчуулсан Хюгогийн түүхэн романы тухай бөгөөд Азийн сонгодог зохиолоос одоо Европын хэлэнд орчуулж байгааг үзэхэд дорно дахины хэл бичгийн эрдэмтэн орчуулж байна. Гэхдээ орчуулахын өмнө их бэлтгэж, тайлбар хийж, хэл зохиолоо баяжуулдаг тухай өгүүлжээ.

Монгол хэл зохиолд европ хэлнээс орж байгаа хүний нэрийн зүйлийг яаж бичих вэ? гэдэг асуудал гарна. Пушкин гэж овгоор нь хэрэглэдэг хэлний ёсоор Пушкиний зохиол гэдэг, бид бас монголоороо Пушкин Александр гээд, Пушкиний зохиол гэвэл зохино, латин үсгийн Н бол кирил үсгийн Х-тэй дүйдэг тул Гюго гэхгүй, Хюго гэж бичих ёстой байсан, зохиолын нэрийг Парисын Марийн сүм, Парисын Эх дагинийн сүм гэдгийн алинаар нь ч нэрлэж болно, ингэж нэр тогтоохдоо хэд хэдэн улсын хэл толиор үзэн хөөж, учрыг нь олж болно гэхчлэн зөвлөн сургасан байна.

“Зохиолч, орчуулагч болоход юу хэрэгтэй вэ”⁶¹

Зохиол бичихдээ, хэл сурахдаа юуны өмнө орчин үеийн дэлхий нийтийн ерөнхий боловсролт хүний хэмжээнд “цээжээ хавтаслах” нь чухал бөгөөд мэддэг хэлээрээ дундад, дээд сургуульд энэ тухай үзээгүй юмаа мэрийн үз гэж сануулжээ.

“Шүлэг орчуулах эрдэм”⁶²

Уншигчийн боловсрол янз бүр агаад гэвч орчуулгыг эх хэлээр унших тул утгыг нь сонирхохоос цаад хэлэнд тэр сонин сайхан зохиол нь ямар байгааг, шүлгийн хэмжээ байдал зэргийн яруу найргийн онцлог нь юу байгааг мэдэхийн арга байдаггүй, гагцхүү орчуулагчийн “амаар будаа иддэг” болохоор Европ зүгийн шүлгийн бүтэц зохиолын аргыг таниулж орчуулан монгол шүлэг бичихэд бас хэрэглэж болно гэж үзжээ. Ихэнх орчуулгад цаад зохиогчийн санаа байхаас шүлгийн хэлбэр бүтэц байхгүй, санаанаас бусад нь орчуулагчийн өөрийн зохиол гэхээр болдог. *Зураачаар жишээлбэл, ямар нэг нэртэй зураачийн зургийг хуулан буулгахдаа өнгө будгаас нь дур мэдэн хаясан лугаа адил зүйл болно. Энэ мэтээр шүлгийн бүтэц хэлбэр агуулга санааг гаргахад ихээхэн чухлыг онцолжээ.*

⁵⁹ Ринчен Б., Марк Твений минь махы нь идэж дээ, дээрх ном, 98-106-р тал.

⁶⁰ Ринчен Б., Зохиол ч биш, орчуулга ч биш, дээрх ном, 118-128-р тал.

⁶¹ Ринчен Б., Зохиолч, орчуулагч болоход юу хэрэгтэй вэ, дээрх ном, 128-139-р тал.

⁶² Ринчен Б., Шүлэг орчуулах эрдэм, дээрх ном, 139-147-р тал.

“Сондгойруулахгүйг эрхэм болгохуй”⁶³

Монгол хэлний найруулгазүйд хоршоо үг, хоршсон аливаа үг хэрэглэхдээ нэгэн өгүүлбэрийн дотор хэд хэд тохиолдвоос сондгойруулахгүйг тун эрхэм болгодог байлаа.

Миний багш нар монголоор бичгийн эх зохиохдоо аман дотроо нам дуугаар гиншин уншиж, найруулгын талаар болсон эссэнийг хянан үзэж, тийнхүү дуудан уншихад баахан эвгүй, илүү дутуу үгтэй, түг таг хийсэн газар, хоёр нэг ахин дахин уншиж байгаад сондгойрсон газар нь нэг нэр үг, нэг үйл үг буюу нэг нөхцөл үг оруулан нэмэх буюу илүүдсэн нэг үг үсэг хасан дугуйлж байдаг асан. Тэгээд тэр нэмсэн буюу хассан үгийн байдлыг ажин үзэхэд яах аргагүй хасвал зохих илүү үг хасаж орхисон байдаг асан. Нэмсэн үгий нь үзэхэд тэр үг нэг нэмсэнээр найруулганд дутуу байсан юм нь гүйцэлдээд эвтэй аятай болсон нь үнэхээр таатай. Эхтэй нь тулгаж үзэхэд яах аргагүй илүү дутуу орчуулсан нь мэдэгддэг. Монгол хэлнээ хоршоо үг, хорших ямар нэгэн үг үхширтэл хэвшсэн байдалтай бус маш уян хатан байдалтай.

Монгол хэлний найруулгазүйг гадарлах ахул руки и ноги гэдгийг гар ба хөл гэдэггүй шүү дээ. Ба гэдгий нь хасна. Энэ тухайд Чой.Лувсанжав багштан “Орчуулагч нар анхааруштай гурван зүйл”⁶⁴ өгүүлэлдээ ч “Ба олширвол барагтайхан орчуулга” гэж тусгайлан тайлбарлаж бичсэн байдаг.

“Хэлний боловсролын учир”⁶⁵

Хэлний боловсролыг чухалчилъя. Сэхээтэн ухамсартай хүн, хувцас хунараа цэвэр боловсон авч явах лугаа адил бусадтай бичгээр буюу амаар харилцахдаа мөн цэвэр боловсон хэлээр санаагаа илэрхийлэхийг хичээх нь орчин үеийн хөгжлийн шаардлага болж байгаа хэрэг. Тулга тойрсон ярианы хэдхэн үгтэй хүн эх хэлээ сайн сурч завдалгүй гадаадад сурч, мэргэжлийнхээ номыг гадаадаар үзэхдээ монголоор юу гэхийг зөв оноож чаддаггүй болсон нь орчуулсан ярьсан зүйлд нь мэдэгдэж байна гэжээ.

“Арга буюу”⁶⁶

Тадеуш гуайн эх зохиолын хэмжээг яг баримталж орчуулах гэхэд кирил үсгээр эгшиг хасах, үеийн адагт хоёр гурван гийгүүлэгч давхцуулах зэргээр бичих дуудах харилцан тохирохгүйгээс арга буюу бүдүүвчилжээ.

⁶³ Ринчен Б., Сондгойруулахгүйг эрхэм болгохуй, дээрх ном, 148-162-р тал.

⁶⁴ Лувсанжав Чой., Орчуулагч нар анхааруштай гурван зүйл, “Орчуулах эрдэм-1”, 1972, 132-136-р тал.

⁶⁵ Ринчен Б., Хэлний боловсролын учир, дээрх ном, 167-173-р тал.

⁶⁶ Ринчен Б., Арга буюу..., дээрх ном. 173-р тал.

“Орчуулгад дутагдал их байна”⁶⁷

Орчуулгын дутагдал боловсрол нимгэнээс болж байна. Шүлэгт цаад зохиолын тусгай хэм хэмжээг анхаарахгүй хялбарчилж байна. Орчуулгын зохиолыг уншигч олондоо тэр улсын утга соёлын онцлог, зохиолчийн бүтээлийн онцлогийг сурталчлах, хэвлэлээр тийн үйлдэх нь хурал уулзалтаас илүү үр дүнтэй байх. Утга зохиолын орчуулагчийг өндөр боловсрол шаардах бүтээлч мэргэжил, зохиолчтой адил хөдөлмөр гэж үзүүштэй.

“Эрдэмтэн орчуулагч эрхэм болж байна”⁶⁸

Улс орнуудад уран зохиолын орчуулгын сургууль, судлал үүсэж, Орчуулгын эрдэм цуврал гарах боллоо, монгол судлал бүхий орноос орчуулагч нарыг Монголд урьж олон улсын монгол утга зохиолын орчуулагчийн их хурал зохион хуралдуулбал олон талаар тстай.

“Хэтдээ бодвол зохих зарим асуудал”⁶⁹

Галигийн асуудлыг шинжлэх ухааны арга зарчмаар боловсруулж хэрэглэх учиртайг дурджээ. Монгол хэлнийхээ авианы хууль ёсонд хэрхэн зохицуулан дуудах, бичих ёсыг боловсруулах чухал.

Энэ ташрамд өгүүлэхэд өнөө цагийн хятад хэлний эрдэмтэд цаг үеийн хэрэгцээ шаардлагыг соргоогоор харж хятадаас монголоор галиглах журмыг батлуулсан нь сайшаалтай.

“Адуунд хатирч, жороо гэж бийн адил..”⁷⁰

Зохиолч Д.Цэдэвтэй ярилцахдаа Гоголийн “Тарас Бульба”-г орчуулсан тухайгаа орос хэлээр санаагий нь мэдэвч монголоор тийм утгыг гаргана гэдгийг бүрэн дүүрэн ухаарахгүй явсан, орос хүний хөмсөг зангиддаг газар хөмсөг зангидуулж, магнай тэнийлгэдэг газар магнай тэнийлгүүлэн чадах тийм монгол найруулгаар орчуулах хэрэгтэй гэж бодсон, адуунд хатирч, жороо, уургач хүлэг гэж бийн нэгэн адил монгол хэлний найруулга ч олон янз шүү гээд найруулах ёсны олон янзыг хутгалгүй, эхийг харгалзан хадгалж орчуулах зүйтэйг сануулан зөвлөжээ.

“Алдарт тунхаг монгол хэлээр гарсан нь”⁷¹

Орчуулахад англи орчуулга их тус болж, зарим герман нэрийг яаж англиар орчуулсныг харж, англи, герман хоёр хэлнээс санаа авч, монгол нэр оноож орчууллаа. Өгүүлбэр зүйн бүтэцээ англи хэлний үйл үгийн олон нарийн цаг нь их төлөв монгол

⁶⁷ Ринчен Б., Орчуулгад дутагдал их байна, дээрх ном, 174-175-р тал.

⁶⁸ Ринчен Б., Эрдэмтэн орчуулагч эрхэм болж байна, дээрх ном, 182-184-р тал.

⁶⁹ Ринчен Б., Хэтдээ бодвоос зохих зарим асуудал, дээрх ном, 184-187-р тал.

⁷⁰ Ринчен Б., Адуунд хатирч, жороо гэж бийн адил, дээрх ном, 188-189-р тал.

⁷¹ Ринчен Б., Алдарт тунхаг монгол хэлээр гарсан нь, дээрх ном, 205-207-р тал.

хэлний нарийн олон цагтай их төстэй байснаар англи орчуулга их тус болсон гэснээс үзвэл олон хэлний мэдлэг маш чухал ажээ.

“Сэтгэгдэл ойролцоо болох вий”⁷²

“Шидэт хүүр” гэж монгол уншигч ахмад үеийн бичигтэн хүнд ихэд алдаршиж, аман уламжлалаар мөн хэлэлцдэг үлгэрийг эрт цагт монгол болгохдоо эртний герегийн нэгэн хан хөвүүний нэр энэтхэг тэр үлгэрт орсныг монголоор орчуулахдаа герег, энэтхэгээр нэрлээгүй, Амгалан эдлэгч хан хөвүүн гэж тэр үлгийн баатрын үйл явдалтай холбогдолтой нэрийг монголоор нэрлэж, учир явдлыг эргэцүүлэн бодоход дөхөм болгосон жишээ бий...

Хоч нэр, ёгт нэрийг болж өгвөл орчуулах нь утгыг гүн гүнзгий ухаж ойлгоход ихэд дөхөм болгодгийг үүнээс мэдүүштэй. “Далан худалч”-ийг үүнтэй утга дүйх солонгос үгээр оноон орчуулсан жишээг өмнөх өгүүлэлдээ⁷³ миний бие дурдсан билээ.

Жич:

Бусад өгүүллийг үл өгүүлэн өгүүлбэл, 1957 онд Монголын зохиолчдын 2-р их хурлын илтгэлдээ⁷⁴, орчуулгын шүүмж ер гардаггүй нь харамсалтай, энэ талаар төвийн сонин, утга зохиолын сэтгүүлч ч ер анзаардаггүйг тэмдэглүүштэй гэжээ. Үүнийг шийдэхийн тулд хэл бичгийн оюутнаас утга зохиолын орчуулагч редакторын бүлэг бий болгож таваас доошгүй жил орос, монгол хэл, орчуулгын зүй, бас дэлхийн утга зохиол, нэг гадаад хэлний хамтаар сургаж практик ажилд нь хоёрдугаар жилээс нь эхлэн юм орчуулж монгол болгох, редакторлох, шүүмж бичих зэргээр сургая, ийм хүнийг гадаадад бэлдэхгүй, эндээ бэлдээд харин тухайн утга зохиол, хэл зэргийг гүнзгийрүүлэн судлуулахын учир тэднийг гадаадад сүүлд явуулж байвал зохино гэсэн үнэтэй санал дэвшүүлжээ.

Дүгнэлт

Дээрх шүүмж, өгүүллүүдэд дэвшүүлсэн санааг хураангуйлбал, Боловсрол мэдлэгийг арвижуулахад орчуулга чухал үүрэгтэй, орчуулагч нар үүргээ ухамсарлаж, эх хэлээ эвдэхгүйг хичээх, аливаа хэлний үгэнд хэд хэдэн салаа утга байдаг, оновчтой үгийг сонгож орчуулах нь түмэн бэрх, нийтийн боловсролд зориулсан бичиг сэлтэд албархуу үг бүү хэрэглэ, шүүмжлээд зогсохгүй орчуулгын чанарыг хэрхэн сайжруулахыг анхаарч зөвлөх, орчуулагч нар нэгэн санаагаар хамтарч орчуулгыг сайжруулъя; Сайн орчуулгаас суралцаж эх хэлний найруулгаа сайжруулах, Монгол аман зохиол их өв соёлоосоо суралцах, амьтан ургамлын нэрийн толь гаргах хэрэгтэй,

⁷² Ринчен Б., Сэтгэгдэл ойролцоо болохвий, дээрх ном, 208-209-р тал.

⁷³ Далан худалчийг 거짓말대장 гэж орчуулсан байдаг. “Далан худалч” үлгэрийн монгол орчуулгын тухайд, “Ази судлал” ОУЭШХ-4, УБ, 2018, 389-р тал.

⁷⁴ Ринчен Б., СССР ба Ардын ардчилсан орны хийгээд дэлхий дахины дэвшилт утга зохиолын орчуулгын тухай, дээрх ном, 81-98-р тал.

жүжигчин, багш, илтгэгч, лектор зэрэг хүмүүс сул үг хэрэглэх, буруу хазгай дуудаж сурснаа залруулж сонсогч олныг хүндлэх, орчуулагч нар өөрийнхөө хэлний зүй тогтлыг хайхарч, хам сэдвийг ухаарах, тааруу зөрүү орчуулга дорхноо баригддаг, эрдэм чадалтай орчуулагч аяндаа урсгалаараа гарч ирнэ гэж хүлээлгүй, тэнхим сургууль байгуулж орчуулгыг хянах, зөвлөх, шүүмж бичих ажил өрнүүлэе; Найруулан засагч хүн ямар үүрэгтэй, орчуулгад монгол хэлэнд нэрийн зүйлд олны тэмдэг хэрэглэдэг зарчмыг огт ухаараагүй; Орчуулахын өмнө сайтар бэлдэж, тайлбар хийж, хэл зохиолоо баяжуулах, нэр тогтоохдоо хэд хэдэн улсын хэл толиор үзэн хөөж, учрыг нь олж болно; Зохиолч, орчуулагч болох хүн юуны өмнө орчин үеийн дэлхий нийтийн ерөнхий боловсролт хүний хэмжээнд “цээжээ хавтаслах” чухал агаад, орчуулагч хүн сониуч байж эрдэмд шамдъя; Шүлгийн бүтэц хэлбэр агуулга санааг гаргаж орчуулж, монгол шүлгийн хэлбэрийг баяжуулах; Монгол хэлний найруулгазүйд хоршоо үг чухал үүрэгтэйг мэдэж, сондгойруулалгүй найруулж, ба-лахаа багасгая; Хэлний боловсролыг чухалчилъя; Гадаадын шүлгийг монголоор хэмжээ хэллэгийг тааруулж орчуулахад зөв бичих дүрмийн саад ч байна; Орчуулгын дутагдал боловсрол нимгэнээс болдог, шүлэгт цаад зохиолын тусгай хэм хэмжээг анхаарахгүй хялбарчилж байна, орчуулгын зохиолыг уншигч олондоо ойртуулж, зохиолын орчуулагчийг зохиолчтой адил хэцүү хөдөлмөр эрхэлдэг гэж үзье; Монголд монгол судлал бүхий орноос орчуулагч нарыг урьж монголоор орчуулах асуудлаар санал солилцон зааж зөвлөе; Галигийн асуудлыг шинжлэх ухааны арга зарчмаар боловсруулж хэрэглэх учиртай; Агуу зохиолчдын бүтээлийг орчуулахад санаагийн нь мэдэвч монголоор утгыг гаргах хүртэл чамгүй хугацаа ордог, найруулгыг зохируулан ашиглах; Орчуулга хийхэд хэд хэдэн хэлний орчуулгыг харж, санаа авах; Зарим зохиолын баатрын нэрийг монголоор нэрлэж, учир явдлыг эргэцүүлэн бодоход дөхөм болгох; Орчуулгын шүүмж ер гардаггүй, редакторын бүлэг бий болгож таваас доошгүй жил гүнзгий суралцуулж дадлагажуулъя гэх мэтээр орчуулгазүйн олон сэдвийг хамруулан бичиж, тухайн үеэр зогсохгүй энэ цаг үед ч тулгамдсан олон асуудлыг шийдлийн хамт өгүүлж их өв үлдээжээ.

“Сайн орчуулагч, бичиг зохиолыг хөрвүүлэхдээ нүд хэдий гадаад бичгийг үзэвч, утгыг найруулан эвлүүлэхэд нэг эгшин хэмээн монгол үгийн ёс зүйгээ ангижрахгүй. Орчуулагч хүн иймийг эрмэлзвээс зохих буй заа.”

Шавь Ц.Шагдарсүрэнгийн “Багш минь таван хүний ажлыг ганцаараа хийж явсан”⁷⁵ гэж хэлсэнчлэн үнэхээр сурч мэдэхийн төлөө, сургаж хүмүүжүүлэхийн төлөө, улс орноо хөгжил дэвшилд хүргэхийн төлөө нэгэн биеийн алжааллыг умартан, сэтгэлээ чилээж, махран зүтгэсэн энэ их эрдэмтний сургаал зөвлөмжөөс нэгийг ч болов авч, алхам ч болов урагшлаасай гэсний үүднээс өчүүхэн өгүүллээ өргөн барилаа.

⁷⁵ <http://zms.mn/> (“Зууны мэдээ” сонины цахим хувилбар: Ярилцах цаг) Ц.Шагдарсүрэн: “Багш минь таван хүний ажлыг ганцаараа хийж явсан”, 2015.11.23

Summary

Translator Akim made a book of articles about translation by Rinchen. In this book Rinchen wrote most of the issues of mongolian translation. Richen not just wrote the issues, but presented the solutions. Therefore value of these articles counted as a masterpiece. So anyone who wanted to learn translation method and research about translation on mongolian, is must to read this marterpiece.

Тодруулан үзэх ном, сайт:

“Ази судлал” Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ, 2018

Чулуунбаатар Л., Орчуулгын тухай лекцүүд, МУИС, УБ, 2017

Лувсанжав Чой., Орчуулагч нар анхаарууштай гурван зүйл, “Орчуулах эрдэм-1”, 1972, 132-136-р тал.

Ринчен Б., Марк Твений минь махы нь идэж дээ, УБ, 1991.

Хүрэлбаатар Л., Монгол орчуулгын товчоон: Сонгодог орчуулгын зарчим уран чадварын асуудалд, 1995.

<http://galaarid.blogspot.com/2006/12/2.html> (Б.Галааридын блог) “Залуу орчуулагчид өгөх зөвлөгөө-2

<http://zms.mn/> (“Зууны мэдээ” сонины цахим хувилбар: Ярилцах цаг) Ц.Шагдарсүрэн: “Багш минь таван хүний ажлыг ганцаараа хийж явсан”, 2015.11.23